

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2019 оны 66 дугаар тогтоолын
хавсралт



“САНХҮҮЧДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ХӨТӨЛБӨР”

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль болон аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.6 дахь заалт зэрэг хууль эрх зүйн баримт заалтын хүрээнд уг хөтөлбөрийг боловсруулж байна.

2018 оны жилийн эцсийн байдлаар Ховд аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн хэмжээнд хүний нөөцийн хувьд 8, сумдын санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн 34, орон нутгийн төсвийн 140 байгууллагад 63 нягтлан бодогч, улсын төсвийн 37 байгууллагад 43 нягтлан бодогч, 177 төсөвт байгууллагад 148 санхүүгийн ажилтан, аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын 2174 байгууллагад 140 гаруй нягтлан бодогч, нийтдээ 280 гаруй санхүүгийн ажилтан ажиллаж байна.

Ховд аймагт санхүүгийн ажилтны хүрэлцээ хангалттай хэдий ч ажиллаж буй ажилтны ур чадварыг хөгжүүлэх, шинэ техник, технологи, программ эзэмшүүлэх, түүнийгээ бүртгэлийн ажилдаа хэрэглэх, санхүүчийн хувийн манлайлал, менежментийн чиглэлээр хөгжих хэрэгцээ шаардлага байгаа нь 2018 оны санхүүгийн тайлагналын үр дүнгээс харагдаж байна.

Сангийн яамнаас төрийн үйлчилгээнд мэдээллийн технологийг нэвтрүүлэх чиглэлээр ихээхэн анхаарч ажиллаж байгаа ба тус яамны нягтлан бодох бүртгэлийн хяналтын газраас аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан балансыг цахим хэлбэрээр авах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Энэ үйл ажиллагаа нь нэг талаас цаг хэмнэж, түргэн шуурхай хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлж байгаа ба мэдээллийн санг үүсгэж байгаад хөтөлбөрийн гол ач холбогдол оршиж байна.

Санхүүгийн тайлан тэнцлийг цахим хэлбэрээр авч эхэлснээс хойш шаардлагатай мэдээ, мэдээллийг хурдан шуурхай авах, аймгийн хэмжээнд тоо мэдээллийг гаргах, нягтлан бодох бүртгэлийн бодлогын үйл ажиллагаанд ихээхэн

ач холбогдолтой болж байгаа. Ийнхүү аж ахуйн нэгж, байгууллага бүрээр тухайн цаг хугацааны санхүүгийн мэдээллийн санг үүсгэснээр аж ахуйн нэгж, байгууллагын орлого, зарлага, мөнгөн хөрөнгийн дүнгийн мэдээлэл бий болохоос гадна буруу, зөрүүтэй алдаатай тайлан баланс гаргаж байгааг хянах боломжтой болж байна. Үүний үр дүнд хоёр өөр, давхар тайлан баланс гаргадаг, тендерт ялах, зээл авахын тулд хуурамч санхүүгийн тайлан баланс гаргах явдлууд багасна.

Нягтлан бодох бүртгэл, аудитын тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн технологийг бүрэн нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх асуудлуудаас гадна шийдэх ёстой үндсэн зорилт бол санхүүгийн тайлагналын олон улсын стандартын нэвтрэлтийг сайжруулах явдал юм.

2018 оны эцсийн тайлан мэдээллээс харахад НББОУС-ын нэвтрэлт бүрэн бус, аж ахуйн нэгжийн цахим тайлан илгээлт 91.4 хувьтай байна.

Санхүү, төсвийн мэдээллийг боловсруулах программ шинэчлэгдсэн, программыг ашиглах санхүүгийн ажилтнуудын мэдлэг дутмаг, энэ талаар сургалт хийгдээгүй, зарим байгууллагуудын нягтлан бодогч нар өөрчлөгдсөн зэрэг шалтгааны улмаас сургалтыг зохион байгуулах шаардлагатай болж байна.

Энэ нь шинэчлэгдэж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан авах цахим программ, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/-ын шаардлагын дагуу санхүүгийн тайлангийн маягтууд, өөрчлөгдсөн тайлангийн эдийн засгийн шинжилгээ хийх аргачлал, байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /НБББББ/-ийг мөрдөх, НББОУС-ыг нэвтрүүлэх зэрэг стандарт, аргачлалыг хэрэгжүүлэх талаар санхүүгийн ажилтнуудыг чадавхжуулан мэргэшүүлэх, шаардлагатай байна.

Хоёр: Хөтөлбөрийн зорилго, зорилт

2.1.Хөтөлбөрийн зорилго

Тайлан, бүртгэлийг цахим программд боловсруулах ажиллагааг бүрэн нэвтрүүлэн төгөлдөршүүлж санхүүгийн салбарын мэдлэг чадвар бүхий хүний нөөцийг төлөвшүүлэн сургах, хөгжүүлэх

2.2.Хөтөлбөрийн зорилт

2.2.1.Санхүүгийн боловсон хүчний мэдлэг, мэргэжлийн чадварыг дээшлүүлэн ажлын чанар, хариуцлагыг сайжруулах

2.2.2.Төрийн сангийн нэгжүүдийн программ хангамжийн ашиглалт, хүчин чадлыг нэмэгдүүлж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, цахим тайлан илгээлтийг бүрэн

нэвтрүүлж, шилэн дансаар дамжуулан санхүүгийн тайлагналын ил тод байдлыг нэмэгдүүлэх

2.2.3. Нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэгийн үр дүнтэй уялдан Төсвийн болон ААНБ-ын НББ-ийн болон анхан шатны баримт хөтлөлт, санхүүгийн ба татварын тайлан хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах

2.2.4. Санхүүгийн ажилтны ёс зүйн үнэт зүйлсийг хэвшүүлэх

Гурав. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа, үе шат

3.1. Хөтөлбөрийг 2019 онд дараах үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ.

Дөрөв. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Хөтөлбөрийн 2.2.1. дүгээр зорилтын хүрээнд:

а. Нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх, эдийн засгийн шинжилгээ хийх, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /НБББББ/-ийг батлан мөрдөх сургалтыг зохион байгуулах

б. НББОУС-ын шаардлагын дагуу санхүүгийн тайлан гаргах, стандартын нэмэлт өөрчлөлтийн сургалтыг зохион байгуулж, нягтлан бодогчдыг мэргэшүүлэх

в. Бүртгэлийн ажлаар тэргүүний газруудын туршлага судлах, шилдэг санхүүгийн ажилтнуудаар илтгэл тавиулах, сургалт зохион байгуулах, өвлүүлэн суралцуулах

г. Аймаг, сумдын зарим байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, үнэлгээ хийж, зөвлөмж өгөх

д. Хяналт, үнэлгээ хийхэд гарсан нийтлэг зөрчил, дутагдлыг арилгуулах талаар ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

ж. Санхүү, төсөвтэй холбогдсон хууль, тогтоомж, Санхүүгийн сахилга, хариуцлага сайжруулах, өр, авлага барагдуулах талаар гарсан аймгийн Засаг даргын албан даалгаврыг бүх шатанд хэрэгжүүлэх арга хэмжээ авах

4.2. Хөтөлбөрийн 2.2.2. дугаар зорилтын хүрээнд:

а. Санхүүгийн ажилтнуудад санхүүгийн холбогдолтой хууль, тогтоомж, Э-төсөв, Э-Тайлан, санхүүгийн программыг ашиглалтын талаар мэргэжил арга зүйн сургалтыг зохион байгуулах

б. Байгууллагуудын төсвийн төлөвлөлт, хуваарилалт, хэрэгжилт, тайлагналтыг цахим хэлбэрээр нэгтгэхэд тогтолцоог хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн зөвлөмж өгөх

в. Санхүү, төрийн сангийн хэлтэс, албадыг өндөр хурдтай тоног төхөөрөмжөөр хангах

г. Санхүүгийн программ хангамж, түүний ашиглалтыг сайжруулах.

4.4.Хөтөлбөрийн 2.2.3. дугаар зорилтын хүрээнд:

а. Санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийг хувийн үнэт зүйлсээс дээгүүр тавин сахин биелүүлэх, төрийн албан хаагчийн тангарагтаа үнэнч байж, ажилдаа чинь сэтгэлээсээ ханддаг төлөвшил суулгах хандлага, төлөвшлийн сургалт зохион байгуулах

Тав. Хөтөлбөрийн хүрэх үр дүн

5.1.Санхүүгийн ажилтнуудын мэдлэг, ур чадвар нэмэгдэж санхүүгийн холбогдолтой хууль, тогтоомжийн хэрэгжилт сайжран ажлын хариуцлага дээшлэнэ.

а. /2018 он тайлангаар Хязгаарлалттай тайлан 67 буюу 32,8 хувь байгаа ба 2019 оны тайлангаар 20 хувь хүртэл буурах, мөн зөрчилтэй тайлан 4 буюу 1,9 хувь, татгалзсан тайлан 1 буюу 0,4 хувь байгаа ба 2019 онд энэ нь 0 хувь болно/

б. Санхүүгийн зөрчлийн хэмжээ буурна.

в. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм хэлбэрэлтгүй хэрэгжиж ажилтнуудын харилцааны соёл дээшлэн иргэдэд үзүүлэх үйлчилгээ сайжирна.

5.2.Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт сайжирч төсвийн хэмнэлтийн горим хэрэгжин өр, авлага буурч санхүүгийн үр ашиг дээшилнэ.

а. Бүх төрлийн бүртгэл бүрэн хөтөлдөг болж хэвшинэ.

б. Төсөв захирагч бүр батлагдсан төсөвт багтаан зарцуулж хэвшинэ.

в. Төсвийн авлага, өглөг буурна.

5.3.Төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, түүнд тавих хяналт, санхүүгийн мэдээ, тайлангийн гаргалт сайжирч, ил тод, нээлттэй байх боломж бүрдэнэ.

а. Төсвийн байгууллагын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн тайланг стандартын дагуу цахим хэлбэрээр боловсруулж тайлагнана.

б. Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан тогтоосон хуулийн хугацаандаа И-баланс цахим хэлбэрээр илгээгдэж баталгаажна.

в. Бүх төрлийн мэдээ, тайлан цаг хугацаандаа гарган тайлагнаж хэвшинэ.

г. Шилэн дансанд мэдээллийг тогтоосон хугацаандаа бүрэн тавьж иргэдэд нээлттэй болно.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Орон нутгийн төсвөөс- 10 000 000 төгрөг

6.2. Бусад эх үүсвэр -9 000 000 төгрөг

Долоо. Хөтөлбөрийн тайлагналт

7.1.Хөтөлбөрийн арга хэмжээ бүрийн санхүүжилтийн гүйцэтгэлийн тайланг анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт бүрдүүлэн нэгтгэн гаргана.

7.2.Хөтөлбөр хэрэгжиж дууссаны дараа зорилт, арга хэмжээ бүрийн заалтын биелэлтийг хүрсэн үр дүнтэй нь гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид, аймгийн Засаг дарга, Засаг даргын зөвлөлд хүргүүлж танилцуулна.

Найм. Хөтөлбөрийн төсөв

дд	Үзүүлэлт	Тоо	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төгрөг/	Тайлбар
1	Сургалт			3 900 000	
1.1.	Санхүүгийн ажилтнуудын сургалт	148		1 800 000	/төсвийн байгууллагын/
1.2.	Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтний сургалт	34		400 000	/төслийн байгууллагуудтай хамтрах/
1.3.	Нягтлан бодогч нарын сургалт	140		1 700 000	/Тусгай хөтөлбөрөөр- ААНБ/
2	Тоног төхөөрөмж			13 100 000	
2.1.	Компьютер	2	1 700 000	3 400 000	/Дөргөн, СТСХ сум/
2.2.	Принтер	2	350 000	700 000	/Дөргөн, СТСХ сум/
2.3.	Программ			6 500 000	/Си-Ти Ес-ийн програм ашигладаг байгууллагууд /
2.4.	Нөүтбүүк	1	2 500 000	2 500 000	СТСХ
3	Бусад			2 000 000	
3.1.	Сумдад ажиллах хяналт, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх /Санхүүгийн нэг өдөр зохион байгуулах/			2 000 000	/Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Аудитын газар, Санхүүгийн хяналт дотоод аудитын албатай хамтрах/
	НИЙТ			19 000 000	